

## **АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЧМЭЛ ТАЙЛАН**

**2025.06.15**

Тус газар нь Захиргаа, хяналтын хэлтэс, Санхүү бүртгэл, орлого, хамралтын хэлтэс, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс, гэсэн 3 хэлтсийн зохион байгуулалттай, 39 ажилтантайгаар үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны байдлаар Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль, НББ-ийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг 50 гаруй хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах үндсэн чиг үүргийг ханган ажиллалаа. Үүнд:

- Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар иргэдийг хамруулж, сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн санхүүжилтийг хуулийн хугацаанд олгож төсвийн гүйцэтгэлийг хангуулах.
- Нийгмийн даатгалын сангийн анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах.
- Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг ажлыг зохион байгуулах.
- Байгууллагын ажиллагсдын чадавхийг бэхжүүлэх, харилцагч байгууллага даатгуулагчдад зориулсан хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах,
- Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, түүний давуу талыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах.

### **Зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын талаар:**

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын санд 2025 оны 5-р сарын байдлаар шимтгэлийн орлогоор 19.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 19.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 101.3 хувиар биелсэн байна.

Тайлант хугацаанд ажил олгогч, 11400 албан журмын даатгуулагчаас төвлөрсөн санд нийтдээ 23.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төлөгдсөнийг НДЕГазарт бүрэн төвлөрүүлэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын 4 сангаас давхардсан тоогоор өнөөдрийн байдлаар нийт 18869 тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээ авагчдад 63.6 тэрбум төгрөгийн зарцуулалт гарсан бөгөөд үүнээс тэтгэврийн даатгалын сангаас нийт 17339 тэтгэвэр авагчдад 60.2 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас нийт 1299 даатгуулагчид 2.5 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 14 тэтгэвэр авагчдад 65 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 217 даатгуулагчдад ажилгүйдлийн тэтгэмжид 939 сая төгрөг олгосон байна.

Аймгийн хэмжээнд идэвхитэй 836 ажил олгогч / 646 ААНБ, 185 төсөвт, 5 цэрэг, цагдаагийн байгууллага/, 11400 заавал даатгуулагч, малчин, туслах малчин сайн дурын даатгалд хамрагдснаар 5 хүртэл жилийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцах хуулийн заалтын хүрээнд аймгийн хэмжээнд 4301 малчныг сайн дурын даатгалд хамруулсан. Үүний үр дүнд төсвөөс 919.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч бүртгэлд тусгасан байна.

Тус газарт 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас 2236 өргөдөл ирүүлснээс 529 тэтгэвэр, 1560 тэтгэмж тогтоолгох өргөдөл, бусад 147 өргөдөл, хүсэлт, гомдол ирсэнийг бүртгэлд авч хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэж НДЕГ, аймгийн ЗДТГ-т шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам хүргүүлж ажиллалаа. Дээрх өргөдөл, санал, гомдлыг агуулгаар нь авч үзвэл:

- ӨН-363
- ХЧАТэтгэвэр-122,
- Тэжээгчээ алдсаны-20,
- Тэтгэврийн тусгай зохицуулалт-24 нийт 529 тэтгэвэр тогтоон ажилласан байна.
- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж-557
- Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж-613
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж-166
- Ажилгүйдлийн тэтгэмж-224 иргэнд нийт 1560 тэтгэмж тогтоон ажилласан байна.

Бусад асуудлаар буюу нийгмийн даатгалын шимтгэлийн залруулга хийлгэх, регистрийн дугаар нэгтгүүлэх, тодорхойлолт гаргуулах, архивын лавлагаа авах болон газрын албан хаагчдаас ирүүлсэн зэрэг 147 өргөдлийг шийдвэрлэн ажилласан байна. Мөн ажилгүйдлийн тэтгэмжийн олголттой холбоотой 5 гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг албан бичгээр хүргүүлэн ажиллаад байна.

### **1.САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ТАЛААР: НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ САР БҮР ЖИГД ХАНГАН БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАЛАА**

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх ажлыг тасралтгүй хэвийн жигд ханган зохион байгуулж ажиллалаа.

| Сар         | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Хувь        |
|-------------|----------------|----------------|-------------|
| 1           | 3355.7         | 3521.3         | 105%        |
| 2           | 6777.6         | 7401.0         | 109%        |
| 3           | 10768.7        | 11356.0        | 105%        |
| 4           | 14931.9        | 15232.0        | 102%        |
| 5           | 19294.9        | 19551.0        | 101%        |
| <b>НИЙТ</b> | <b>55129.9</b> | <b>57061.0</b> | <b>104%</b> |

## **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН УРСГАЛ АВЛАГЫГ БУУРУУЛАН АЖИЛЛАВ.**

НДЕГазраас 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах “ жил болгон зарласан. Энэ хүрээнд иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тайлагналын мэдээллийг үнэн зөв бүрдүүлэх болон шимтгэл төлөлттэй холбоотой цалин, төрлийн залруулгыг хүсэлтийг тухай бүр шийдвэрлэх, иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар орон зай, цаг хугацаанаас үл шалтгаалан авах, шимтгэл төлөлтөндөө хяналт тавих талаар тайлбарлан таниулан ажиллалаа.

а) Нийгмийн даатгалын шинэ систем нэвтэрсэн, сумын байцаагч нар ажлын байран дээрээсээ сикос системд ажиллах боломжгүй байгаа зэрэг цаг үеийн байдлаас шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бүрдүүлэлтийг сайжруулах, сайн дурын даатгуулагчийн бүртгэлийг үнэн зөв хөтлөх, хувийн хэргийн баримт бичгийн бүрдлийг хангах ажлыг хяналтандаа авч “Хувийн хэргийн бүрдэл- Эмх цэгцийг сайжруулах ” аяныг 18 сумын нэгжүүдэд зохион байгуулж 8 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Уг ажлаар хувийн хэргийн бүрдлээ хянах, баяжуулах, системд бүртгэх мэдээллийн бэлтгэл байдлыг ханган газарт 3-4 удаа ирж 2-7 өдөр ажиллаж ХХДХэмжээ өөрчлөгдснийг зөв бүртгэх, ногдуулалтыг бүрэн хийх, шимтгэл төлөлтийн талаар тухайн даатгуулагчдад мэдээллэх, хянах ажлыг гүйцэтгэлээ. Үүний үр дүнд сайн дурын даатгуулагчийн ногдуулалт төлөлтийг бүрэн хийх, сайн дурын даатгуулагчийн тайлангийн кт үлдэгдлийг бууруулах, хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангах, зогсоогдсон хувийн хэргийг архивын нэгж болгон хүлээлгэн өгч ажиллалаа.

б) Уг ажлаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” –ын дотооддоо байцаагч, мэргэжилтнүүдэд таниулах, ойлголт мэдлэгийг бататгах чиглэлээр сумын байцаагч нарт сургалт, гадагшаа ажил олгогч, даатгуулагчдад чиглэн тэдэнд тайлбарлан таниулах сургалтыг нийт ажил олгогчдод зохион байгуулж энэхүү журмын хэрэгжилтийг сайжруулах, ач холбогдлыг ойлгуулах, мэдлэгийг дээшлүүлэн ажилласан. Үүний үр дүнд 795 ажил олгогч, давхардсан тоогоор 10007 албан журмын даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг цаг хугацаанд нь нийгмийн даатгалын цахим системд бүртгэн баталгаажуулан ажилласан. Түүнчлэн энэхүү журамд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг насжилтаас хамааран шимтгэл төлөгч 795 ажил олгогч байгууллагын дарга, захирал, эрхлэгч, нягтлан бодогч нарт шимтгэлээ хугацаандаа төлөх талаарх сануулах заавар зөвлөгөөг, 9 ажил олгогчдод улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх, 9 ажил олгогчдын арилжааны банкны харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоох, 21 ажил олгогчдод мэдэгдэл, 2 байгууллагыг шүүхийн байгууллагад шилжүүлэн, 3 байгууллагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн ажиллав. Үүний үр дүнд 748.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн урсгал авлагыг 220.1 сая төгрөгт хүргэж, 70.6 хувиар бууруулан, НДШ-н орлогод эзлэх авлага 0.09 хувьтай гарах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР:

2025 оны төсөв Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 тоот тушаалаар 1835.1 сая төгрөгийн төсөв батлагдсан. 2025 онд батлагдсан төсвийн хуваарь нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/49, А/129 тоот тушаалаар өөрчлөлт орж нийт төсөв 1864.5 сая төгрөг болон өөрчлөгдөн батлагдсан. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Сангийн сайдын 211 дүгээр тушаал, холбогдох хууль, заавар журмын хүрээнд зохион байгуулж ажиллалаа.

### 2023-2025 оны батлагдсан төсвийг графикаар үзүүлбэл:



**2023-1249.8**

**2024-1653.4**

**2025-1864.5**

1. Тус Нийгмийн даатгалын газар нь 2025 оны 01 сарын 01-нээс Монгол улсын Засгийн газрын 240, 241 тогтоолуудыг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82, 83, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дүгээр тогтоолуудыг хяналтандаа авч 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоож, батлагдсан төсөвтөө багтаан ажиллагсдынхаа цалинг олгож, өр авлага үүсгэлгүй ажиллах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна. 2025 онд тус газар нь 1864.5 сая төгрөгийн төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс ажиллагсадтай холбоотой зардалд 1727.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 41.6 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 15.1 сая төгрөг, бусад урсгал зардалд 79.9 сая төгрөг батлагдсан төсөвтэйгөөр үйл ажиллагаа явуулж

байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар хагас жилийн төсвөөс 88.7 сая төгрөгийг буцаан татсан нь цалингаас бусад зардал 5.4 сая төгрөгийн өглөг үүсэх хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй байна. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасны дагуу иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа.

## 2. Бүтэц орон тоо

Тус газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/51 тоот тушаалаар баталсан Удирдлага-1, Захиргаа хяналтын хэлтэс-11, Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэс-7, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс-7, сумын байцаагч, мэргэжилтэн-18 нийт 44 орон тоо батлагдсанаас 39 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулан орон тоо хэтрүүлэлгүйгээр ажиллаж, ажлын байрны ачааллыг нягтруулж ажиллалаа.

### 2.1. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

/сая.төг/

| Он      | Батлагдсан цалингийн сан /жилээр/ | Гүйцэтгэл | Тайлбар                                                                       |
|---------|-----------------------------------|-----------|-------------------------------------------------------------------------------|
| 2025 он | 1533.9                            | 719.2     | Батлагдсан цалингийн санд багтааж өр, авлага үүсгэлгүй ажиллах ХБГ-тэй байна. |

2025 оны байдлаар батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаандаа дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

2025 онд Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалыг мөрдөн эдийн засгийн ангилал, бүлэг хооронд гүйлгэлгүй батлагдсан төсвийн хүрээнд зарцуулан ажиллаж байна. Засгийн газрын 83 дугаар тогтоолоор баталсан хөдөө орон нутагт тасралтгүй 5 жил ажилласан 1 төрийн захиргааны албан хаагчид 8.7 сая төгрөг, тухайн онд тэтгэвэр тогтоолгох 1 албан хаагчид 22.3 сая төгрөгийн тэтгэмж, урамшууллыг олгохоор төсөвт тусгасан байна. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын тайланг GreenFinance санхүүгийн програмаар бэлтгэн тайлагнаж байна. GreenFinance санхүүгийн програм нь хүний нөөцийн GreenHRM програм, ТАЦНСистем, Төрийн сангийн ehuulga.mof.gov.mn –үүдтэй уялдан хуулийн хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.

### Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал

| 2023-2025 оны тогтмол зардлын төсөв, гүйцэтгэл |                  |          |         |          |
|------------------------------------------------|------------------|----------|---------|----------|
| №                                              | Тогтмол зардал   | 2023 он  | 2024 он | 2025 он  |
| 1                                              | Гэрэл, цахилгаан | 10.0 сая | 9.4 сая | 10.5 сая |
| 2                                              | Түлш, халаалт    | 6.6 сая  | 7.1 сая | 7.6 сая  |
| 3                                              | Цэвэр, бохир ус  | 0.3 сая  | 0.4 сая | 0.4 сая  |

2025 оны хагас жилийн байдлаар байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулан өр, авлагагүй ажиллах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

## **2.2 Албан томилолтын зардал.**

Ажиллагсадын албан томилолтыг олгохдоо газрын даргаар батлуулсан удирдамж, албан томилолтын хуудас, албан томилолтоор ажилласан тайланг үндэслэн баримтын бүрдлийг ханган олгож хэвшсэн. Тайлант онд Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүний хүрээнд газрын албан томилолтын зардалд 2.4 сая төгрөгийн төсөв батлагдсан нь хагас жилийн байдлаар 100%-ийг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

## **2.3 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардал, нийгмийн батлагааг хангах ажлын хүрээнд:**

Тус онд “Хүүхдийн эрхийг хамгаалах баяр”-ын өдрийг тохиолдуулан газрын албан хаагчдын 78 хүүхдэд 2.3 сая төгрөгийн гарын бэлэг, мөн хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдэд 0.1 сая төгрөгийн гарын бэлэг, цагаан сарын баярыг тохиолдуулан тус газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 24 ахмад настанд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг олгоход 0.9 сая төгрөг, шинэ хүүхэдтэй болсон 3 албан хаагч, ар гэрийн гачигдал тохиолдсон албан хаагчид 0.6 сая төгрөгийг тус тус олголоо.

## **2.4 Үндсэн хөрөнгө:**

Үндсэн хөрөнгийн 2025 оны эхний үлдэгдэл 945.3 сая төгрөг байна. Хагас жилийн байдлаар худалдан авсан болон акталсан үндсэн хөрөнгө байхгүй болно.

## **Тооллого:**

2024 оны жилийн эцсийн тооллогын дүн мэдээг ТӨБЗГ-ын [burtgel.pcsp.gov.mn](http://burtgel.pcsp.gov.mn) цахим хуудсанд бүртгэх ажлыг гүйцэтгэлээ. Энэ ажлын хүрээнд улсын бүртгэлийн болон байгууллагын газар эзэмшиж буй гэрчилгээг ГХБХГазар, Улсын бүртгэлийн байгууллагад байгаа мэдээлэлтэй тулган нягталсан. Үүний үр дүнд нийгмийн даатгалын байгууллагын эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нэгдсэн судалгааг батлагдсан маягтын дагуу дагуу гарган цахим системд бүртгэсэн. Түүнчлэн цахимаар болон цаасаар НДЕГазарт хугацаанд нь хүргүүлэн ажиллаа.

- Нийгмийн даатгалын байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах саналыг ӨХБЗөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт НДЕГазарт 2025 оны 01 –р улиралд хүргүүлсэн. Тус газрын үндсэн хөрөнгийн бүртгэлд 945.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнээс барилга багууламж 705.8 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 14.1 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 149.9 сая төгрөг, тавилга эд хогшил 57.3 сая төгрөг, програм хангамж 2.8 сая, газар 15.1 төгрөг тус тус бүртгэлтэй байна. Хагас жилийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг газрын даргын А/18 тушаалаар томилсон. Ажлын хэсэг нь хөрөнгийг тоолох, зурагжуулан баримтжуулах, ажилтнуудын эд хөрөнгийн картын мэдээллийг шинэчлэх ажлыг гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар хөрөнгөтэй холбоотой дутагдсан болон илүүдсэн зөрчил илрээгүй байна.

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийн хүрээнд 2024 оны газрын даргын А/20 тоот тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн

баталсан. Дээрх зөвлөл нь хөрөнгө бэлтгэх, актлах, тооллогын дүнг хэлэлцэх зорилгоор 2025 онд 3 удаа хуралдсан байна.

- Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслээгүй болно.

### **Хөрөнгө оруулалтын зардал**

2025 онд тус газарт хөрөнгө оруулалтын батлагдаагүй болно.

## **3. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:**

### **3.1 ШИМТГЭЛ:**

Нийгмийн даатгалын шинэчилсэн цогц мэдээллийн санд 836 ажил олгогч, 11400 албан журмын даатгуулагч, 9900 сайн дурын даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн бүртгэхэд хяналт тавин ажиллаа. 2025 оны хагас жилийн байдлаар 114 ажил олгогч, 1102 албан журмын даатгуулагч, 5100 сайн дурын даатгуулагч шинээр нэмэгдсэн байна.

2024.01.01-ээс “Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн багц хууль” хэрэгжсэнтэй холбоотойгоор нийгмийн даатгалд хамрагдах даатгуулагчдын тоо нэмэгдэж байна.

### **3.2 ТЭТГЭВЭР:**

**Төлсөн зөрчлүүд илрээд байна.**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтаар илэрсэн актаар тавигдсан Улсын байцаагчийн актын 2024 оны үлдэгдэл 69 иргэний 403326.9 мянган төгрөгөөс 47 иргэний тэтгэврийн суутгал хийж 15 иргэн бүрэн барагдаж 78884.9 төгрөгийг барагдуулж 324442.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. 2 иргэнийг шүүхэд өгөхөөр материалыг бүрдүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтаар илэрсэн актаар тавигдсан Улсын байцаагчийн актын 2024 оны үлдэгдэл 69 иргэний 403326.9 мянган төгрөгөөс 47 иргэний тэтгэврийн суутгал хийж 15 иргэн бүрэн барагдаж 78884.9 төгрөгийг барагдуулж 324442.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. 2 иргэнийг шүүхэд өгөхөөр материалыг бүрдүүлэн ажиллаж байна. Дотоодын хяналт, шалгалтаар илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тавин актын барагдуулалтыг санхүүгийн тайлан мэдээтэй тулган шалган мэдээ тайланг цаг тухай бүрд нь хүргүүлэн ажиллааж байна.

**Нийгмийн даатгалын авлагыг сан сангаар харуулбал:**

тэтгэвэрийн даатгалын санд 2024 оны үлдэгдэл 120122,7 мянган төгрөг, 2025 онд 9314,9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 64579,8 мянган төгрөгийг барагдуулж 64857,8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Ажилгүйдлийн даатгалын санд 2024 оны үлдэгдэл 19881,6 мянган төгрөг, 2025 онд 4883.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 13824,1 мянган төгрөгийг барагдуулж 10940,9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Тэтгэмжийн даатгалын санд 2024 оны үлдэгдэл 2174,1

мянган төгрөг, 2025 онд 3294,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 4655.0 мянган төгрөгийг барагдуулж 813,1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### **Цахим хяналт шалгалт:**

НДЕГазрын шалгалтаар акт тавигдсан 69 хүний 495134,6 мян.төгрөгийн авлагатайгаас 15 хүний 112751,3 мян.төгрөгийг барагдуулж 54 хүний 382383,4 мян.төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. 47 тэтгэвэр авагчаас сар бүр суутгал хийж байна. 42 тэтгэвэр авагчийн тэтгэврээс 50 хувиар, 5 тэтгэвэр авагчийн тэтгэврээс 50-иас дээш хувиар суутгал хийж байна.

### **Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар:**

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг ажилдаа мөрдлөг болгон мэдээллийн сайтад Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг батлагдсан маягтын дагуу сар, улирал бүр мэдээг НДС, НДГазар тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэж ажилласан. Үүнд: НДС дээр 28 чиглэлээр 68 мэдээлэл, НДГ нь 29 чиглэлээр 68 нэр төрлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь ил тод мэдээллэсэн байна. Хугацаа хоцроосон мэдээлэл гараагүй болно. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.06.10 өдрийн 03/1203 албан тоотын дагуу Shilen.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг хянан тайланг хуулийн хугацаанд илгээн ажиллаа. Засгийн газраас хэрэгжүүлэ буй Go.mn сайтыг мэдээлэл технологийн ажилтан, сургалт сурталчилгаа хариуцсан байцаагч нартай хамтран хөгжүүлэлтийг хийж байна.

### **Дотоодын хяналт шалгалтын талаар:**

Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу Архангай аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй, нэгж байгууллагуудад төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн бөгөөд Архангай Эх голомтын илч ХХК, Архангай ус суваг /ОНӨААТҮГ/, Цэцэрлэг хотын тохижилт үйлчилгээний газар /ОНӨААТҮГ/, Эрдэнэмандалын хөгжлийн дэд бүтэц /ОНӨААТҮГ/, Хайрхан хөгжлийн дэд бүтэц /ОНӨААТҮГ/, Адуучин удам ХХК, Гост трейд ХХК, Долоон бар ХХК мөн барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй ААНБ-д урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлын хүрээнд Цагаан сүмбэр ХХК, Тамирын цахиур ХХК, Эсгэл ХХК, Газрын гагнаас ХХК, Цаж ХХК, Мөнхөд баярт хөхий ХХК, Эм си эс си ХХК зэрэг ААНБ-г Төрийн хяналт шалгалтын тухай, Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол улсын Засгийн

газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хяналт шалгалт хийх нийтлэг журам буюу 479 дүгээр тогтоолын” дагуу шалгаж, “Хяналт шалгалтанд хяналтын хуудас хэрэглэх журам, хяналтын хуудас шинэчлэн батлах тухай” Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан Ажилтны Нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас 07.3.1-ээр эрсдэлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдсан Гост трейд ХХК- Ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор шимтгэл ногдох орлогыг нуусан, эсхүл хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн заалтыг зөрчсөн байх тул Нийгмийн даатгалд тайлагнаагүй цалингийн сангийн зөрүүг он оноор нь гаргаж 2022 онд 199.943.058 мянган төгрөг, 2023 онд 361.515.960 мянган төгрөг, 2024 онд 201.250.442 мянган төгрөг нийт 762.709.460 төгрөгийн цалингийн санд ногдог 183.050.270,4 төгрөгийн цалин хөлс түүнтэй адилгах орлогыг нуун дарагдуулж, хэмжээг нь багасгаж тайлагнасан нь шалгалтын явцал тогтоогдсон тул Архангай аймгийн цагдаагийн газарт шилжүүлсэн.

Мөн дээрх байгууллагуудад нийтлэг илсэрсэн зөрчил нь ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ бусад нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар гаргасан тушаал заавартай танилцаж хөдөлмөрийн дотоод журамд ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил асуудал тусгаж хэрэгжүүлээгүй, ахмадын сан байгуулаагүй, Нийгмийн даатгалын шимтгэлд ноогдох орлогыг үнэн зөв тодорхойлоогүй, ААНБ-с ажилтанд хоол, унаа, түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар дотоод журам хөдөлмөрийн гэрээнд огт тусгаагүй, ажилчидын ээлжийн амралтыг бодитоор бодож олгоогүй, ажил мэргэжлийн ангилал хэсгийг үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтод заасны дагуу үнэн зөв хийгээгүй, Ажилд орсон, чөлөөлсөн, мөн өөрчлөлт орсон тушаалыг тухай бүр шимтгэлийн цахим системд оруулаагүй нь Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх А/199 журам болон Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. Ажил олгогч нь бодит цалин хөлснөөс болон салбарын хөдөлмөрийн хөлснөөс дээгүүр тооцож НДШ-төлж ажиллах тал дээр анхаарч ажиллах талаар зөвлөгөө өгсөн. Дээрх ААНБ-уудын хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 82,5%, эрсдэл үүсэх магадлал дунд гэж үнэлэгдлээ. Дээрх хяналт шалгалтанд хамрагдсан 2 ААНБ-д зөрчлийн хэрэг нээж тус хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 4 ААНБ-д улсын байцаагчийн албан шаардлаг хүргүүлээд байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>3</sup> дугаар зүйлийн 5<sup>3.1</sup> дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын Хяналт үнэлгээний Үндэсний хорооны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2024 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/06 дугаартай удирдамжийн хүрээнд Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад Төрийн хяналт шалгалтын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль

болон тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журмын хэрэгжилтэд шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, дүгнэлт өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалт хийлээ.

2022-2024 онд 918 даатгуулагчид 2331539.3 мян төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тогтоож, олгосон байна. Үүнээс түүвэрлэн нийт даатгуулагчдын 55 хувь буюу 504 даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж тогтоосон хувийн хэрэг, санхүүгийн баримтад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. 1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж, албан журмаар шимтгэл төлж эхэлсэн”, Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 5.5-д заасан “Тэтгэмж авагч нь ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон эсвэл тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон бол энэ тухайгаа нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэн, тэтгэмж олголтыг зогсоож, тооцоо хийнэ” гэснийг зөрчиж ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажил хөдөлмөр эрхэлж байгаа эсэхэд хяналт тавихгүйгээр тэтгэмж илүү олгож, оны эцэст санд буцаан төлүүлсэн; 2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасан “Нийгмийн даатгалын байгууллага ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн арилжааны банкна дахь дансаар дамжуулан сар бүр олгоно”, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 438 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”-ын 4.1-т заасан “Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 2.5-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, даатгуулагчийн арилжааны банкин дахь дансаар, дамжуулан сар бүр олгоно” гэснийг зөрчиж ажилгүйдлийн тэтгэмж тогтоолгож буй даатгуулагчийн тэтгэмжийг хуваарийн дагуу олгоогүй, дараагийн сард олгогдож буй тэтгэмжтэй хамтатган (бөөн дүнгээр) олгосон байна. Газрын даргын баталсан удирдамжийн дагуу Цэнхэр, Жаргалант, Эрдэнэмандал сумдуудад хяналт шалгалт ажлыг зохион байгуулж 5 төсөвт байгууллагад



15421,6 мянган төгрөгийн акт, 5831,8 мянган төгрөгийн алданги ногдуулан бүрэн барагдуулан ажиллаа. Гост трейд ХХК 183,0 сая төгрөг, Хангайн төгөл ХХК нь 53,0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн нь тогтоогдож хуулийн байгууллагад шилжүүлэн ажиллаа. Мөн 2 байгууллагад 167,4 мянган төгрөгийн акт 50,0 алданги ноогдуулж акт алдагийг тогтоосоон хугацаанд бүрэн барагдуулан ажиллаа. Авто зам ХК-г 2022-2024 оны баримтыг шалган зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээ аван

ажиллалаа. Хамтарсан шалгалтын хүрээнд Бүрэн ар ХХк, Цагаан эрчис ХХК хяналт шалгалтын ажил үргэлжилж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 2 дугаар сарын 14 өдрийн баталсан удирдамжийн дагуу Булган мэргэжил сургалтын төв, 5-р сургууль, Шинэ алтан зам ХХК-д хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

#### 4. Авлигын эсрэг хууль, тогтоомжийн талаар:

АТГ-ын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсээс УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024.04.02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах” 5 дугаар тогтоолыг танилцуулах сургалтыг цахимаар ЭБАТ-ны зүгээс газар, сумдын байцаагч нарт “Мэдүүлгийн цахим системийн ашиглалт, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал” сэдэвт сургалтуудыг танхимаар тус тус зохион байгууллаа. Дээрх сургалтын үр дүнд мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим сан (<http://meduuleg.iaac.mn>)-д мэдүүлгээ шинэчлэн гаргасан 18 байцаагчийн “баталгааны маягт”-ыг хэвлүүлэн авч баталгаажуулалтыг хийж, Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэн гаргасан зурагт хуудас, гарын авлагыг байгууллагын Шударга ёс хөгжил дэвшилд-110 мэдээллийн самбарт тогтмол байршуулан албан хаагч нарт танилцуулахын зэрэгцээ газрын цахим хуудас болох [arhangai.ndaatgal.mn](http://arhangai.ndaatgal.mn) сайтад Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, нийтлэл, зурагт хуудас, авлигын хор уршиг, сургалтын талаарх мэдээллүүдийг байшуулж ажиллаа. Авлигын эсрэг хамтдаа нэгдье рийл хийж иргэдэд түгээж ажиллаа. 62 лайк, 28 шейр хийсэн байна.




Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар ZOOM сургалт зохион байгуулж гишүүд бүрэн хамрагдаа.

Callpro үйлчилгээ дээр холбоос 7 дээр авлигын мэдээлэл авах боломжтой болсон.рагдлаа.

## **5.Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл**

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл нь эхний хагас жилийн байдлаар 6 удаа хуралдсан байна. Нийт 100 иргэний өргөдөл гомдлын 5 өргөдөл гомдлыг буцаан 95 шийдвэрлэн ажилласан байна.



## **6.Эрүүл мэндийн магадлалын зөвлөл**

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь шинэчилсэн дүрмийн дагуу иргэнийг байлцуулахгүйгээр холбогдох баримт бичигт үндэслэн хагас жилийн байдлаар 21 удаа хурал хийсэн. Нийт 3168, үүнээс НД сангаас 1609, НХ сангаас 1559, Үйлдвэрлэлийн осол 12, шинээр 126, цуцлагдсан 89, нас барсан 6, шилжин ирсэн 2, шилжин явсан 6 иргэн байна. Долоо хоног бүрийн лхагва гаригт группын хурлаа хийж, хурал бүрийн дараа алдааны жагсаалтыг хянаж, цахим сангийн бүрдүүлэлтийг тулгаж, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрт хяналт тавин, иргэний амбулаторийн карт, эрүүл мэндийн байгууллагын цахим




бүртгэл, эмчийн үзлэгийн бүртгэл зэрэгт тулгуурлан хяналт тавин шийдвэрлэж байна.ажиллаж байна.

Мэдээ, тайлан, судалгааг үнэн зөв, хугацаанд нь гарган, 2025 оны хагас жилийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, гишүүдийн хуралд оролцсон бүртгэл, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд зарцуулж буй цагийн бүртгэлийг үнэн зөв гаргаж ЭММТЗ-рүү тайланг ABLE- р илгээсэн.


Цахим мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж, нууцлалын найдвартай байдлыг хангаж, 2025 оны эхний хагас жилээр НХ, НД-ын массивтай тулгаж,хяналт тавьж, программд овог, нэр, регистрийн дугаар зөрүүтэй гэх мэт зөрчлүүдийг тухай бүр нь залруулан ажиллаа.

**“Эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгоход анхаарах асуудал”** сэдвээр сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын11-ний өдрүүдэд аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүд, сумдын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд 8 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 156 хүн оролцож цаашид зөрчил, дутагдал гаргахгүй тал дээр онцгойлон анхаарч ажиллахыг сануулсан, эмч нарын асуусан асуултанд хариулан харилцан ярилцсан үр дүнтэй сургалтууд боллоо.



Нэгдсэн эмнэлэг, өрхийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүд сургалт хийж байна.сумдын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд цахим сургалт хийв.

ЭММЗ-ийн дарга, гишүүдэд авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, болзошгүй алдаа, дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор авилгатай тэмцэх газартай хамтран 2025 оны 1-р сард 1 удаа, 2025 оны 05 сарын 13-нд танхимаар, 2025 оны 05 сарын 28-нд цахимаар, нийт 3 удаа сургалтуудыг хийсэн. Ашиг сонирхолын зөрчил гаргаагүй ажилласан.



2025-03-24-нд Архангай аймгийн ХХҮГ-аас ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа сэдэвт сургалтанд ЭММЗ-ийн 2024 оны тайлан болон үйл ажиллагааны талаар танилцуулж харилцан санал солилцлоо.

2025-05-30-нд Монголын хөдөлмөр заслын холбооноос зохион байгуулсан “Хөдөлмөр заслыг хүн бүрд” сэдэвт чуулганд оролцон Архангай аймгийн ЭММЗ-ийн үйл ажиллагааны товч тайланг танилцуулан илтгэл тавьсан. Чуулганд Эрүүл мэндийн газар, өрх, сумд, Нэгдсэн эмнэлгийн сэргээн засахын эмч, болон хөдөлмөр засалчид оролцож ХБИ-дэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Тархины гэмтэл ба тархины цус харвалтын дараах хөдөлмөр засал эмчилгээний үр дүн, Хорт хавдрын үеийн хөдөлмөр засал эмчилгээ, Ахилын шөрмөс сэргээх мэс заслын дараах хөдөлмөр заслын эмчилгээ, Тархи доргилтын эмчилгээнд бариа заслын аргыг сонгож буй шалтгааны хүчин зүйлсийг судалсан нь зэрэг сэдвүүдээр лекц уншиж, харилцан санал солилцсон үр дүнтэй сургалт болсон.



2025 оны хагас жилийн байдлаар Архангай аймгийн хэмжээнд ХЧА өндөртэй сумдыг жагсаан нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд мэдээллийг нээлттэй, ил тод хүргэх арга хэмжээний хүрээнд оролцогч талуудын албан ёсны цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээнд байршуулж, тэдгээр сумдын засаг дарга нар, Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран нээлттэй сурталчлах, иргэдэд чиглэсэн сургалт, уулзалт, зохион байгуулж ажиллахыг төлөвлөж байна.

2025 оны 02 сарын 03-ны өдөр аймгийн АВ телевизд “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ыг танилцуулах, хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх шинэчлэгдсэн заалт, хувь, хугацаанд орсон өөрчлөлтийг танилцуулсан REEL бичлэг хийлгэж, цахим орчинд түгээн ажиллаа.

2025-02-21-нд магадлагч эмч нарын өглөөний ярилцлагыг Архангай аймаг зохион байгууллаа. Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, магадлагч эмч нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, сайн туршлага солилцох, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үр дүнтэй ярилцлага болсон.

2025-03-28-нд Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран “ХБИ-ийн хүртээмжийн орчин, мэдээллийн хүртээмж, түүний хэрэгжилийг сайжруулахад талуудын оролцоо, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр уулзалтыг Хүний эрхийн Үндэсний комисс, Архангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, ХБИ-ын холбоодтой хамтран ЗДТГ-ын ногоон танхимд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт нийт 30 гаруй ХБИ идэвхтэй оролцон санал бодлоо солилцсон.




ЭММТЗ-өөс 09/16 тоот удирдамжаар ЭММЗ-ийн гишүүдийг чадавхижуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, судалгаа, шинжилгээний ажилд татан оролцуулах, магадлалын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх, сайн туршлага солилцох зорилгоор “ЭММЗ-ийн гишүүдийн судлаач бүлэг” байгуулан багуудад хуваарьлан сэдвүүд өгч удирдагч багшаар ахлуулан эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичих арга зүйн сургалтуудыг сар бүр хийж байгаа.

Судлаач бүлгийн багийн хуваариар Архангай, Дархан, Орхон, Ховд аймаг, Улаанбаатар хотоос БГД, ЧД, СХДүүргүүд хамтран тухайн аймаг дүүргийн эмнэлгийн хуудасны бичилт, олголтын судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар судалж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагчийн эмнэлгийн хуудас олгох журам”-ыг танилцуулах, хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор “Эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгоход анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлага болон амбулаторийн эмч нарт эмнэлгийн ажилчид хуурамчаар эмнэлгийн хуудас бичүүлэхийг завдсан тохиолдолд гарсан хохирлыг бичсэн эмч нь хариуцан төлнө гэсэн заалтыг хатуу анхааруулан сургалт хийсэн. Нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн хуудас авсан эмч, эмнэлгийн ажилчдын амбулаторын карт, оношийн үндэслэл, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл, Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэр зэргийг зөв эсэхийг хянан, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

2025-06-05-нд “Хөдөлмөрийн чадвар алдалт болон Эмнэлгийн хуудасны олголт” сэдвээр LIVE хийж иргэдийн сонирхсон асуултад хариулсан ба нийт 7500 хүний хандалттай үр дүн өндөртэй live болсон.




## 7. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Тус газарт 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 2236 өргөдөл ирсэний 529 тэтгэвэр, 1560 тэтгэмж тогтоолгох өргөдөл, бусад өргөдөл 147 ирснийг бүртгэлд авч хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэж ажиллалаа.

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар шинээр 363 өндөр насны, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 122, тэжээгчээ алдсаны 20, тэтгэврийн тусгай зохицуулалт 24 нийт 529 тэтгэврийг тогтоогоод байна.


2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоон үзүүлэлт:



2025 оны 06 сарын байдлаар тэтгэвэр авагчийн тоон мэдээ

- өндөр насны тэтгэвэр
- хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр
- тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- цэргийн тэтгэвэр

## 2025 ОНЫ 06 САРЫН 10-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ТЭТГЭМЖИЙН ТООН МЭДЭЭ



- ЖАТ
- ХЧТА
- ОРШУУЛГА
- АЖИЛГҮЙДЭЛ

ЖАТ -613

ХЧТАТ -557

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ -224

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР  
БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ -  
166

Нийгмийн даатгалын газраас лавлагаа авах иргэдийн хүсэлтийг хүлээн авч 2006-2025 онуудад ажилласан хугацааны лавлагааг QR кодоор шимтгэл төлсөн газар харгалзалгүй тухай бүр нь, 1995-2006 онуудад ажилласан хугацааны лавлагааг газар дотооддоо ажлын нэг өдөрт, бусад газруудад ажлын 3 хоногт багтаан гаргаж хөнгөн шуурхай үйлчилж байна. 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар газар дотооддоо 18, QR кодоор 117, бусад газраас 65, иргэд даатгуулагч нарт 179 лавлагаа олгоод байна. Нийт 379 лавлагааг олгосон байна.


## 8. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Нийгмийн даатгалын ач холбогдол, 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн дагаж мөрдөх Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.

2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар байцаагч ажилтнуудыг чадавхжуулах 8 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 120 ажилчдыг хамруулсан байна. Ажил олгогч албан байгууллага, иргэд даатгуулагчид, сумын иргэд, малчдад чиглэсэн 21 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2521 гаруй иргэд, даатгуулагчдыг хамруулаад байна.

### Дотооддоо чиглэсэн сургалтын талаар:



1. Газрын албан хаагчдын жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлон сургалт авах байгууллагуудад хүсэлт хүргүүлэн ажилласан ба одоогоор 8 удаагийн сургалтыг алба хаагчдаа оруулсан байна. “ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ”, “АВЛИГАГҮЙ АРХАНГАЙ”, “Баяр хөөртэй суралцахад суралцах нь”, “Төвийн танилцуулга, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, Хандлага ба орчин”, “ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАНИУЛАХ ӨДӨР” Ерөнхий газар болон Архангай аймгийн Тамгын газраас зохион байгуулсан сургалт зөвлөгөөн, “Хуримтлал” “Эрүүл иргэн”, “Хадгаламжийн ач тус”, “Насан туршийн





суралцахуйн төвөөс -4, Татвараас 1, Онцгой байдлын албанаас 1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс 1, Төрийн банк хамтарсан 1 гэх мэт ....



2.Сумдын байцаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мэдээллийн шинэ систем болох Sicos, Portal програмууд дээр хэрхэн ажиллах талаарх, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, шимтгэлийн өр авлага барагдуулах зөвлөмж тайлант сургалтыг цахимаар 7 хоног бүр СБОХХ-ээс зохион байгуулж ажилласан, давхардсан тоогоор 105 сумдын байцаагч хамрагдлаа.



3.Нийгмийн даатгалын ерөнхий газраас явуулсан цахим 9 удаагийн сургалтанд давхардсан тоогоор газрын 81 байцаагч, ажилчдыг хамрууллаа.



### “ МАЛЧИН ТАНД ЗОРИУЛАВ”

Боршур бэлдэж сумдын байцаагч нараар дамжуулан малчдад СДД-ын талаар суртачилан таниулах ажлын хүрээнд:

2025 оныг “Хамралт нэмэгдүүлэх” жил болсонтой холбоотойгоор Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар СБХОХ-ээс зохион байгуулсан ажлын хэмжээнд хийгдсэн ажлын хүрээнд хэвлэлийн газартай гэрээ байгуулж үнийн саналыг авч 3000 ширхэг малчдад зориудсан тараах материал хэвлүүлэв.



Сумдын байцаагч нарт хуваарилан өгч малчдыг хамруулан ажилласан байна.

| №    | Сум              | Тоо  | Хариуцсан байцаагч |
|------|------------------|------|--------------------|
| 1    | Хашаат сум       | 135  | Г.Лхагвадулам      |
| 2    | Их тамир сум     | 251  | Б.Даваасүрэн       |
| 3    | Өгийнуур сум     | 100  | З.Болор-Эрдэнэ     |
| 4    | Төвшрүүлэх сум   | 150  | Т.Жигдэн           |
| 5    | Жаргалант сум    | 150  | Э.Жавзмаа          |
| 6    | Хайрхан сум      | 160  | Н.Золзаяа          |
| 7    | Тариат сум       | 200  | Х.Номинчулуун      |
| 8    | Цэнхэр сум       | 200  | Ц.Сосорбарам       |
| 9    | Хотонт сум       | 51   | Г.Бадамгарва       |
| 10   | Батцэнгэл сум    | 250  | О.Цэвэлмаа         |
| 11   | Цахир сум        | 150  | Д.Тогтохсүрэн      |
| 12   | Чулуут сум       | 250  | Э.Нямбаяр          |
| 13   | Хангай сум       | 150  | Б.Соёл-Эрдэнэ      |
| 14   | Эрдэнэмандал сум | 150  | Б.Баасансүрэн      |
| 15   | Булган сум       | 153  | Ж.Нармандах        |
| 16   | Өндөр-Улаан сум  | 150  | Д.Досмаа           |
| 17   | Өлзийт сум       | 150  | Ж.Болормаа         |
| 18   | Цэцэрлэг сум     | 150  | Д.Оюунжаргал       |
| 19   | Эрдэнэбулган сум | 50   | Б.Гэрэгт-Од        |
| НИЙТ |                  | 3000 | тараасан           |



### **“ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ЖИЛ-2025” НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ”**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчлан сэргийлэх салбар зөвлөл, Цагдаагийн газар, Прокурорын газар, Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар хамтран 2025 онд “Иргэдийн оролцоог дэмжих” жилийн хүрээнд НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ зохион байгуулж Тариат, Өндөр-Улаан, Хангай, Цахир, Ихтамир, Хотонт, Жаргалант, Эрдэнэмандал, Өлзийт, Хайрхан, Өгийнуур, Батцэнгэл, Хашаат, Төвшрүүлэх, Чулуут, Цэнхэр, Булган сумдын иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хууль, сайн дурын даатгалын талаар мэдээлэл хүргэж иргэдийн асуултанд хариулж, зөвлөгөө өглөө. нийт 6000 гаруй иргэд, даатгуулагчид хамрагдлаа.



### **“МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН-2025”**

Ихтамир, Цэнхэр, Хотонт, Төвшрүүлэх, сумдад “Малчдын зөвлөгөөн-2025” зохион байгуулж иргэд даатгуулагчдад 2025.05.03, 2025.05.07, 2025.05.09, 2025.05.30-ны өдрүүдэд зохин байгууллаа. Тус зөвлөгөөнөөр Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, Нийгмийн даатгалын хуулийн талаарх мэдээллийг хүргэх



зорилгын хүрээнд Нийгмийн даатгалын ач холбогдол, Тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Сайн дурын даатгал, Малчны сайн дурын даатгалын талаарх мэдээлэл хүргэж, хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт үзлэг хийж ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлон заавар, зөвлөгөө өгч нийгмийн даатгалын цахим үйлчилгээ буюу **portal.ndaatgal.mn** вэб хуудсаар хэрхэн гэрээ байгуулаж, хүсэлт илгээх талаар зөвлөгөө мэдээлэл хүргэж, иргэд даатгуулагчдын гар утсанд аппликейшнийг суулгаж баталгаажуулан ажиллалаа. Уг арга хэмжээнд нийтдээ 600 гаруй даатгуулагч, иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэлээ.

### **ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦОО-2025 Өдөрлөг**

Өндөр-Улаан сумын Хануй багт “Эмэгтэйчүүдийн оролцоо 2025 өдөрлөг зохион байгуулагдаж, Өндөр-Улаан сумын Нийгмийн даатгалын байцаагч Д.Досмаа, Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын байцаагч нар Өндөр-Улаан сумын Хануй багийн иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан, сургалт мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.





### **5. Иргэд, даатгуулагч нарт нийгмийн даатгалын хууль тогтоомжийг олон нийтийн сүлжээнд сурталчлан таниулах ажлын хүрээнд:**

5.1. “Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар” гэсэн пэйж хуудсыг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар пэйж хуудас нь 528 дагагчаар нэмэгдэж нийт дагагчийн тоо 5328 дагагчтай болоод байна. Пэйж хуудсаар дамжуулан энэ оны 06 сарын 15-ны өдрийн байдлаар 42 удаагийн мэдээ, 60 удаагийн постер, 6 удаагийн шууд лайв, 13 удаа рийл бичлэг бэлдэж нийтэлсэн бөгөөд давхардсан тоогоор 206250 гаруй даатгуулагчдад мэдээ хүргэсэн, Call Pro үйлчилгээ **7507-9000** дуудлагын

дугаарт холбоос /7/ нэмж авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллуулж байна. 2025.01.01-06.15-ны хүртэл 7507-9000 дугаарт 919 дуудлага ирснээс 839 иргэдэд утсаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

5.2. Нийгмийн даатгалын байгууллагын зүгээс АВ телевизтэй хамтран ажиллаж удаагийн ярилцлага, шторкийг тус телевизийн студээр ажил олгогч, иргэд-даатгуулагч нарт хүргэн ажиллалаа. Үүнд: 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс “Ажилгүйдлын тэтгэмж”-ийн олголтын тайлан мэдээг танилцуулж, ажилгүй иргэдийн талаарх мэдээлэл, мөн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй ХХДХ өөрчлөлтийн талаар мэдээ мэдээллийг бэлтгэн телевизээр дамжуулан иргэд даатгуулагчдад цаг үеийн мэдээллийг хүргэж ажиллалаа.



## 9. 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨВ, ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДАН ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хүснэгт 1

| № | Байгууллагын нэр | Шийдвэрлэлт                    |                        |                       |                             |                  | Шийдвэрлэлт /%/ |
|---|------------------|--------------------------------|------------------------|-----------------------|-----------------------------|------------------|-----------------|
|   |                  | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгуул шилжүүл | Хугацаа Хэтрүүлж шийдвэрлэс | Хугацаа болоогүй |                 |
|   |                  |                                |                        |                       |                             |                  |                 |

|            |     |      |      |   |  |   |      |
|------------|-----|------|------|---|--|---|------|
| 1          | НДГ | 2236 | 2236 | - |  | - | 100% |
| <b>ДҮН</b> |     | 2236 | 2236 | - |  | - | 100% |

**2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар иргэдээс НДГ-т иргэдээс 11-11 төвд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт**

Хүснэгт 2

| №          | Байгууллагын нэр | 11-11 төвөөр | Тусгай дугаарын утсаар хандсан |
|------------|------------------|--------------|--------------------------------|
| 1          | Архангай НДГ     | 5            | Хариуг шийдвэрлэсэн болно      |
| <b>ДҮН</b> |                  | 5            | -                              |

**2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар иргэдээс НДГ-т хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт/ агуулгаар/**

Хүснэгт 3

| №               | Өргөдлийн хэлбэр |             |
|-----------------|------------------|-------------|
| 1               | Өргөдөл, Хүсэлт  | 2231        |
| 2               | Гомдол           | 5           |
| 3               | Санал            |             |
| 4               | Мэдээлэл         |             |
| <b>Нийт дүн</b> |                  | <b>2236</b> |

## 10.ХАВРЫН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Эрдэнэбулган сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/36 дугаар захирамж, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/58 дугаар захирамжуудад заасны дагуу Нийгмийн даатгалын газрын хуваарьт их цэвэрлэгээ хийх газрыг өвсний фондноос замын 2 талын 300 метр газар, Донойн гүүрний хэсэг мод хүртэл өлөнгийн хамт 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд хуваарьт газраа газрын хамт олноороо хог хаягдал цэвэрлэх шуудай, тармуур, хүрзийг бэлтгэн цэвэрлэх талбайн хог хаягдлыг бүрэн цэвэрлэж ажиллалаа.

Цэвэрлэсэн талбайгаас 35 шуудай хог хаягдал гарч, хаягдлыг Эрдэнэбулган сумын ажил хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, хариуцсан ажлаа үр дүнтэй зохион байгуулан ажиллаад байна.



2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр



**2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр**

## **11.“ТЭРБУМ” МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД**

### **БҮХ НИЙТИЙН МОД ТАРИХ ӨДӨР**

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/222 дугаар аймгийн Засаг даргын захирамжийн дагуу “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих аяны хүрээнд Урд тамирын гол татмын дагуу Нийгмийн даатгалын газар нь 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 38 ширхэг Улиас мод тарьж, суулгалаа. Тарьж суулгасан модоо 2025 оны 05 дугаар сарын 16, 23, 30-ны өдрүүдэд 3 удаа усалж арчлан ажиллалаа.

Модны ач тус:

- Хүчил төрөгч ялгаруулдаг
- 100 гаруй жил насалдаг
- Хурдан ургадаг
- Ашигтай үнэрт бодис ялгаруулдаг
- Агаарын бохирдлыг багасгадаг
- Дуу чимээ намасгадаг давуу талтай юм.

Байгаль дэлхийгээ эрүүлээр хадгалж үлдэхэд хүмүүс бидний үүрэг оролцоо чухал билээ.



**АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**